ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 25 өдөр Дугаар А/148 Улаанбаатар хот

Дүрэм, журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар 6.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, магадлан итгэмжлэх зөвлөлийн дүрэм"-ийг нэгдүгээр, "Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журам"-ыг хоёрдугаар, "Шалгалт авах журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хоёр, гуравдугаар хавсралтаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн орлогч дарга, шалгалтын комиссын дарга /Н.Чулуунбанди/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 243 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ

0009840

Харилцаа холбоо,мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 12 сарын 25-ны өдрийн А/1748 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

5202935
1119288568

МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү дүрмээр “Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, магадлан итгэмжлэх зөвлөл” (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Зөвлөлийг салбарын төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр байгуулна.

1.3 Зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

1.4 Зөвлөлийн орлогч дарга нь шалгалтын комиссын дарга байх бөгөөд шалгалтын комиссыг байгуулж ажиллана.

1.5 Зөвлөлийн зорилго нь мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, сунгах, зэрэг ахиулах болон цуцлах (цаашид “мэргэшлийн зэрэг олгох” гэх) ажлыг удирдан зохион байгуулахад хяналт тавих энэхүү тогтолцоог цаашид тасралтгүй явуулж боловсронгуй болгоход оршино.

1.6 Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр нь мэргэшлийн зэрэг горилогчдын төлбөр, хандив тусламж болон бусад орлогоос бүрдэнэ.

ХОЁР. ЗӨВЛӨЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Зөвлөл нь мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохих журмын хүрээнд удирдан зохион байгуулах, түүнтэй холбогдсон асуудлуудыг судалж, хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.2 Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах ажиллагааг явуулна. Зөвлөлийн дарга, гишүүд нь ижил саналын эрхтэйгээр хуралд оролцоно.

2.3 Мэргэшлийн зэрэг горилогчдод зэрэг олгохтой холбогдсон журмуудыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулна.

2.4 Зөвлөлийн орлогч дарга нь хэлэлцэх, шийдвэрлэх асуудлаас хамааруулан зөвлөлийн бүрэлдэхүүнээс тухайн хуралд оролцох гишүүдийг сонгох ба зөвлөлийн хурлын ирц нь 50 ба түүнээс дээш хувьтай байх ёстой. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн хурлыг онлайн хэлбэрээр зохион байгуулж болно.

2.5 Зөвлөлийн шийдвэр нь хуралд оролцож буй гишүүдийн 75 ба түүнээс дээш хувийн санал авсан тохиолдолд хүчинтэй байна.

2.6 Зөвлөлийн шийдвэр нь хурлын тэмдэглэл байх бөгөөд шийдвэрийг зөвлөлийн даргын тогтоолоор баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн зэрэг олгох эцсийн шийдвэрээс бусад шийдвэрийг зөвлөлийн орлогч дарга баталгаажуулж болно.

ГУРАВ.ЗӨВЛӨЛИЙН ЭРХ

3.1 Зөвлөл өөрийн үйл ажиллагаа, менежментийг сайжруулахтай холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, төлөвлөгөө батлах, тайланг хэлэлцэнэ.
3.2 Мэргэшлийн зэрэг горилогчдын сургалтын төлбөрийн хэмжээг тухайн үеийн инфляцийн түвшинг харгалзан тогтооно.
3.3 Мэргэшлийн зэрэг олгох шалгалтын комиссыг /цаашид комисс гэх/ Зөвлөлийн орлогч дарга /шалгалтын комиссын дарга/-ын тушаалаар байгуулна. Комиссын гишүүд нь тухайн салбарын тэргүүлэх мэргэжилтэн, их дээд сургуулийн профессор багш, эрдэмтдээс бүрдэнэ.
3.4 Комисс нь мэргэшлийн зэрэг олгох сургалтын агуулга, төлөвлөгөө, зэрэг горилогч мэргэжилтний бүтээлийн тайлан, тодорхойлолт, мэргэшлийн чиглэл зэргийг хэлэлцэж батална.
3.5 Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл комиссын шийдвэрийг хүчингүй болгох, шинээр томилох, шалгалтыг дахин зохион байгуулах эрхтэй.

ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1 Зөвлөлийн гишүүд /цаашид гишүүд гэх/ нь мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалтын бүх үе шатанд ашиг сонирхлын зөрчилгүй, хөндлөнгийн нөлөөгүй байх зарчмыг баримтлан хяналт тавина.
4.2 Гишүүд нь холбогдох хууль, дүрэм, журмыг чанд баримтлан үнэнч, шударга, ёс зүйг эрхэмлэнэ.
4.3 Зөвлөл нь шалгалтын комиссын үйл ажиллагаанд хяналт тавих, шалгаруулалт явуулж дууссанаас хойш 30 хоногийн дотор зэрэг олгосон, сунгасан, зэрэг ахиулсан болон цуцалсан эсэхийг зөвлөлийн даргын тогтоолоор баталгаажуулж, вэб хуудсаар мэдээлнэ.
4.4 Мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон асуудлаар өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, цаг хугацаанд нь барагдуулна.
4.5 Сургалтын чанар, багш нарын талаар төгсөгчдөөс үнэлгээг нээлттэйгээр авч үйл ажиллагаандаа дүгнэлт хийж сургалтын агуулга, боловсон хүчний чадавхийг сайжруулахад анхаарч комисст зохих зөвлөмж өгч хяналт тавьж ажиллана.
4.6 Энэхүү журмаар зохицуулагдахгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актыг баримтлан шийдвэрлэнэ.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 12 сарын 25-ны өдрийн А/148 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмаар Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, салбарын төрийн захиргааны дээд байгууллагаас баталгаажуулж хяналт тавихтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэшлийн ур чадварын түвшин, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээл, туршлагыг үнэлэх, тэдний ажил үйлчилгээний чанарыг үнэлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.3 Захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд ажилтныхаа мэргэжлээ дээшлүүлэх талаарх хүсэлтийг комисст сургалт зохион байгуулах зарын дагуу ирүүлнэ. Энэ нь мэргэжилтний зэрэг олгох, сунгах, зэрэг ахиулах болон цуцлах үндэслэл болно.

1.4 Мэргэжилтний зэрэг нь мэргэшсэн ба зөвлөх гэсэн шатлалтай байна.

1.5 Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох Зөвлөлийн шийдвэрийг ШУТИС-ийн Мэдээлэл, Холбооны Технологийн Сургууль хэрэгжүүлнэ.

1.6 Мэргэжлийн шалгалт, төгсөлтийн ажил болон тайлан хамгаалалтыг ШУТИС-ийн Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуульд мөрддөг нийтлэг журмын дагуу зохион байгуулна.

1.7 Мэргэшсэн болон Зөвлөх зэрэгтэй мэргэжилтэнүүдийн холбогдох баримт бичиг, материалыг ШУТИС-ийн Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуульд, зөвлөлийн шийдвэрийг салбарын төрийн захиргааны байгууллагад тус тус хадгална.

ХОЁР. МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЧИГЛЭЛ

2.1 Мэргэшлийн зэрэг олгох чиглэлийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

2.1.1 Сансрын болон хөдөлгөөнт холбоо
2.1.2 Радио, телевизийн өргөн нэвтрүүлэг
2.1.3 Дамжуулах байгууламж, нягтруулгын систем
2.1.4 Шуудан холбоо
2.1.5 Электрон техник, тоног төхөөрөмжүүдийн автоматжуулалт
2.1.6 Мэдээллийн сүлжээ
2.1.7 Мэдээллийн системийн аюулгүй байдал
2.1.8 Программ хангамж, мэдээллийн систем

ГУРАВ. ЗЭРЭГ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Зөвлөх инженерийн зэрэг горилогчид дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
3.1.1 Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;
3.1.2 Мэргэшсэн инженер зэрэгтэй 3-аас доошгүй жил ажилласан байх;
3.1.3 Шинэ бүтээл, ашигтай загвар, патентын гэрчилгээ, техник технологийн шийдэл,
3.1.4 норм, норматив гэх мэт мэргэжлийн болон мэргэшсэн чиглэлээрээ бүтээлтэй, 4-өөс доошгүй улсын болон олон улсын чанартай төсөлд оролцсон байх;
3.1.5 Мэргэжлийн болон ёс зүйн зохих шаардлагыг хангасан байх;
3.1.6 Мэдээлэл, холбооны технологийн салбарт шинээр нэвтэрч байгаа техник, технологийн талаар онолын өргөн мэдлэгтэй байх;
3.1.7 Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний зохион байгуулалтын талаар мэдлэгтэй байх;
3.1.8 Горилогч нь мэргэжлийн чиглэлээр олон улсад зөвшөөрөгдсөн ахисан түвшний гэрчилгээтэй байх;
3.1.9 Мэдээллийн сүлжээний чиглэлээр зэрэг горлогч нь “CISCO-ийн CCNP”-ын гэрчилгээ, эсхүл түүнтэй дүйцэхүйц гэрчилгээтэй байх;
3.1.10 Мэдээллийн системийн аюулгүй байдлын чиглэлээр зэрэг горлогч нь “CISCO-ийн CCNA Security”-ын гэрчилгээ, эсхүл түүнтэй дүйцэхүйц гэрчилгээтэй байх;

3.2 Мэргэшсэн инженерийн зэрэг горилогчид дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
3.2.1 Магистрын зэрэгтэй байх;
3.2.2 Сүүлийн 6 жил мэргэжлээрээ ажилласан байх;
3.2.3 Бүтээл, мэргэжил дээшлүүлэх талаар зохих шаардлагыг хангасан (техник технологи норм, норматив, томоохон захиалгат төсөл 2-оос доошгүй).
3.2.4 Мэргэжлийн болон ёс зүйн шаардлагыг хангасан байх;
3.2.5 Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний зохион байгуулалтын талаар мэдлэгтэй байх;
3.2.6 Горилогч нь мэргэжлийн чиглэлээр олон улсад зөвшөөрөгдсөн гэрчилгээтэй байх;
3.2.7 Мэдээллийн сүлжээний чиглэлийн зэрэг горилогч нь “CISCO-ийн CCNA”-ын гэрчилгээ, эсхүл түүнтэй дүйцэхүйц гэрчилгээтэй байх;

ДӨРӨВ.МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОХ ХҮСЭЛТ ГАРГАХ

4.1 Горилогч нь дараах баримт бичгийг электрон хэлбэрээр шалгалтын комисст илгээнэ.
- 4.1.1 Анкет
- 4.1.2 Ажил байдлын тодорхойлолт
- 4.1.3 Боловсролын үнэмлэх, дипломын хуулбар
- 4.1.4 Мэргэжил дээшлүүлсэн байдлыг нотлох гэрчилгээ, бусад баримтууд
- 4.1.5 Бүтээлийн жагсаалт

4.2 Горилогч нь шаардлагатай бол холбогдох бусад байгууллагын тодорхойлолттой байж болно.

4.3 Горилогч нь материалыг худал мэдүүлэх, эсвэл бусдын материалыг ашигласан нь нотлогдвол зэрэг олгохоос түдгэлзэнэ.

4.4 Горилогч онцгой бүтээлтэй ажилласан тохиолдолд түүний хүсэлт болон тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн комисс нь энэ журмын 3 дугаар зүйлд заасан хугацааг харгалзахгүйгээр зэрэг олгох саналыг зөвлөлд хүргүүлнэ.

4.5 Дараах тохиолдлуудад зэрэг горилогчийн хүсэлтийг үндэслэн комисс хэлэлцэж мэргэжлийн шалгалтаас чөлөөлж болно.
- 4.5.1 Мэргэжлээрээ 25 жилээс дээш хугацаагаар тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан бол;
- 4.5.2 Улсын болон олон улсын хэмжээний үр ашигтай төсөл, хөтөлбөр удирдаж хэрэгжүүлсэн, мэргэжлийн ном гаргаж нийтлүүлсэн, хууль эрх зүйн акт, норм, норматив батлуулж мөрдүүлсэн зэргээр онцгой бүтээлтэй ажилласан бол;
- 4.5.3 Мэргэжлийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан бол;

ТАВ. МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ

5.1 Мэргэжлийн шалгалт, төгсөлтийн тайлан хамгаалалтыг комисс зохион байгуулна.

5.2 .Мэргэжилтний мэдлэгийн түвшин, мэргэшлийн ур чадварыг шалгалтаар, бүтээл, туршлагыг зохих тодорхойлолт, бүтээлийн тайланг холбогдох журмын дагуу магадлан шалгах замаар үнэлж дүгнэнэ.

5.3 Горилогчийн шалгалтын дүн, мэргэшлийн ур чадвар, бүтээл, туршлагыг үнэлсэн комиссын саналыг үндэслэн зөвлөлийн тогтоолоор мэргэшлийн зэргийг гурван жилийн хугацаагаар олгоно.

5.4 Зөвлөх инженерийн мэргэшлийн зэрэг авсан мэргэжилтэнд эзэмшигчийн нэр, бүртгэлийн дугаар, зэргийн хүчинтэй байх хугацаа бүхий гэрчилгээ, энгэрийн тэмдэг, хувийн тамга олгоно. Мэргэшсэн инженерийн мэргэшлийн зэрэг авсан мэргэжилтэнд гэрчилгээ олгоно.

ЗУРГАА. ЗЭРЭГ СУНГАХ, ЦУЦЛАХ

6.1 Мэргэшсэн болон зөвлөх инженерийн мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацааг гурван удаа сунгуулах ба дараагийн удаад хугацаагүй сунгана.

6.2 Зэргийн хүчинтэй хугацааг сунгуулах тохиолдолд энэхүү журмын 4 дүгээр зүйлийн 4.5-4.6.3-д заасан нөхцлийг харгалзан үзнэ.

6.3 Зэргийн хүчинтэй хугацааг сунгуулах хүсэлт гаргагч нь өнгөрсөн хугацаанд мэргэшсэн чиглэлээрээ хийсэн ажлууд, мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, холбогдох тодорхойлолтын хамт хүсэлтээ комисст ирүүлнэ.

6.3.1 Зэргийн хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд сунгах, зэрэг ахиулахыг комиссын гишүүдийн санал хураалтаар шийдвэрлэнэ.

6.3.2 Горилогчийн шалгалтын дүн, мэргэшлийн ур чадвар, бүтээл, тайланг үнэлсэн комиссын дүгнэлтийг үндэслэн зөвлөлийн тогтоолоор мэргэшлийн зэргийг гурван жилийн хугацаагаар сунгана.

6.4 Дараах тохиолдлуудад зэргийг бууруулах, цуцлах шийдвэрийг зөвлөлөөс гаргаж болно.

6.4.1 Зэрэг бууруулах, цуцлах талаар байгууллага, хувь хүмүүсээс ирүүлсэн санал гомдлыг хянан хэлэлцэх;

6.4.2 Горилогч нь материалыг худал мэдүүлэх, эсвэл бусдын материалыг ашигласан нь нотлогдвол зэрэг сунгахаас түдгэлзэнэ.

6.4.3 Тайлант хугацаанд мэргэшсэн чиглэлээрээ ажил үйлчилгээ явуулаагүй;

6.4.4 Шалгаруулалтад тэнцээгүй;

6.4.5 Хууль эрх зүйн зөрчил гаргасан;

ДОЛОО. ЗЭРЭГТЭЙ МЭРГЭЖИЛТНИЙ ЭРХ

7. Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй инженер нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

7.1 Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй инженер нь тодорхой төсөл, хөтөлбөр болон ажилд зөвлөх;

7.2 Зөвлөх инженер нь төсөл зохиохын зэрэгцээ бусдын зохиосон төслийг шалгах, экспертиз хийх эрхтэй ба зөвхөн өөрөө гүйцэтгэсэн, оролцсон эсвэл удирдсан, хянаж зөвлөсөн ажлын гүйцэтгэлийн тайлан дүгнэлт, технологийн болон техникийн акт, баримт бичиг, зураг төсөл зэрэгт гарын үсэг зурж хувийн тамга дарах;.

7.3 Мэргэшсэн инженер нь шинээр зохион бүтээх, угсрах болон өргөтгөл, шинэчлэлт, засвар хийх техник, байгууламж, тоног төхөөрөмжийн техник эдийн засгийн тооцоо хийх, төсөл зохиох ажлыг бие даан хийх;

7.4 Зэрэг олгох болон зэргээ сунгуулах шалгалтад хүндэтгэх шалтгааны улмаас орж чадаагүй бол уг шалтгаанаа нотлох баримт бичиг, тайлбарыг комисст өгч шийдвэрлүүлэх;

7.5 Шалгуулагч нь шалгаруулалтын талаарх гомдол, саналаа комисст өгч шийдвэрлүүлэх;

7.6 Шалгуулагч нь шалгалтандаа тэнцээгүй бол нэг жилээс доошгүй хугацааны дараа дахин шалгалт өгөх хүсэлт гаргаж комиссоор шийдвэрлүүлэх;

7.7 Мэргэшлийн зэрэг эзэмшигч нь Зөвлөлийн үйл ажиллагаа, удирдлага менежментийг боловсронгуй болгох, салбарын технологи-инновацийг хөгжүүлэх талаар санал гаргах, төсөл, хөтөлбөр санаачлах, санал гаргах;

7.8 Зэргийг түдгэлзүүлсэн, мөн цуцлуулсан инженер тухайн шийдвэрээс хойш нэгээс доошгүй жилийн хугацааны дараа зэрэг олгох шалгаруулалтанд оролцох асуудлыг энэ журмын 5-р бүлгийн заалтын дагуу комисст хандан хүсэлт гаргах;

7.9 Мэргэшлийн зэрэг эзэмшигч нь мэргэжлээрээ ажиллаж байгаа бол Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу нэмэгдэл цалин авч болно. Зөвлөх инженерийн зэрэгтэй бол үндсэн цалингийн 20 хувь, мэргэшсэн инженерийн зэрэгтэй бол 15 хувь хүртэл байна.

НАЙМ.ЗЭРЭГТЭЙ МЭРГЭЖИЛТНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

8.1 Зэрэгтэй мэргэжилтэн нь ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, норм стандарт, журам зааврын дагуу техник технологийн зохих түвшинд, хариуцлагатай, чанартай, аливаа ашиг сонирхлын зөрчилд авталгүйгээр гүйцэтгэнэ.

8.2 Зэрэгтэй мэргэжилтнүүд өөрөө удирдаж гүйцэтгүүлсэн эсхүл өөрөө хийсэн, зөвлөж, хянаж баталгаажуулсан ажлын үр дүн, чанарыг бүрэн хариуцна. Хэрэв, ажлын үр дүнгээс хохирол учирсан бол холбогдох хуулийн хариуцлага хүлээнэ.

8.3 Зэргээ цуцлуулсан зөвлөх инженер хувийн тамга, гэрчилгээгээ зөвлөлд хураалгана.

ЕС. КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

9.1 Комисс нь үйл ажиллагаагаа Салбарын төрийн захиргааны байгууллагын удирдлага буюу “Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, магадлан итгэмжлэх зөвлөл”-д жилд нэг удаа тайлагнана.

9.2 Комиссын үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод, бусад зохих шатны хяналтын байгууллагууд хяналт тавьж болно.

_____OoO_____